



Баянжаргалан сумын засаг  
даргын тамгын газар-Т

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
ДОТООД АУДИТЫН АЛБА  
УЛСЫН (АХЛАХ) БАЙЦААГЧИЙН  
ЗӨВЛӨМЖ

2024.06.13 № 01

Зөвлөмж хүргүүлэх тухай

Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газар, тусгай сангуудын 2024 оны 5 сарын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдэд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. А/01, А/02, А/03, А/33 захирамжууд, Б/01, Б/02, Б/04 тушаалуудын дугаар давхардаж бүртгэгдсэн байгаа тул цаашид шийдвэрүүдийн бүртгэлүүдийг давхардуулахгүй байхад анхаарч ажиллах
2. Авто машины хувийн хэргийн баяжилт хийж, хөтлөх
3. 2024 оны 3 сард 20 сая төгрөгийн худалдан авалт хийсэн өвсний гэрээний хэрэгжилт хангагдаагүй шаардлага хангаагүй өвс ирсэн гэж буцаагдсан байгаа тул нягтлан бодох бүртгэлийн бичилтийг залруулах, шилжүүлсэн мөнгийг авлагаар тусган залруулга хийх, өвсний орлого, зарлагыг анхан шатны баримтаар баталгаажуулан хөтлөх
4. Хандив тусламжаар ирсэн биет хөрөнгийг хандивлагчийн зарлагын баримтыг үндэслэх ба анхан шатны баримтгүй тохиолдолд зах зээлийн үнээр байгууллагын дэргэдэх өмч хамгаалах зөвлөл болон сумын үнийн комиссоор үнэлүүлэн шийдвэр гаргаж байгууллагын даргын зөвшөөрлөөр хөрөнгийн орлогод бүртгэж байх
5. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын дотоод хяналтын нэгжийг байгуулж, төлөвлөгөө гарган журмын дагуу зохион байгуулах.
6. Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах
7. Хөрөнгө худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх
8. Хоршоо хөгжүүлэх сангийн Төсөл сонгон шалгаруулах товыг зээлийн эргэн төлөлт, санхүүжилтийг харгалзан сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлсэн тохиолдолд тухан сумын иргэдийн Төлөөлөгчдыг хурал тогтооно гэсэн заалтыг хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг 7 сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд нотлох баримтын хамт албан бичгээр ирүүлэх.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ  
БАЙЦААГЧИ С.БАРХАСМАА

482497002